

## **Хилийн боомт, орон нутаг дахь нэгжийн албан хаагчдад сургалт зохион байгууллаа**

Төрийн албаны зөвлөлийн “Шинэтгэлээр түүчээлсэн салбар зөвлөл аян”-ы хүрээнд Гадаадын иргэн, харьяатын газрын дэргэдэх Ёс зүйн дэд хорооноос байгууллагын даргын 03 дугаар сарын 11-ний өдрийн А/118 дугаар тушаалаар баталсан “Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хууль тогтоомжийг сурталчлах, соён гэгээрүүлэх ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх” удирдамжийн дагуу албан хаагчдыг ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх, хилийн боомт, орон нутаг дахь нэгжийн албан хаагчдад сургалт нөлөөллийн ажлыг үе шаттай зохион байгуулж байна.

Ёс зүйн дэд хорооны гишүүд, сэтгэл зүйч Д.Оюуномин, Удирдлагын академийн доктор, дэд профессор А.Алтанзул нартай хамтран “Харилцааны ёс зүй ба бидний хандлага”, “Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хууль”-ийн талаар сургалт, уулзалтыг 03 дугаар сарын 31, 04 дүгээр сарын 09-ний өдрүүдэд Агаарын замын боомт хариуцсан газар, Дорноговь аймаг дахь газарт тус тус зохион байгууллаа.

Мөн Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хууль тогтоомжийн агуулгын хүрээнд албан хаагчдын хууль тогтоомжийн мэдлэгийг үнэлэх, сорилын үр дүнг үндэслэн ажил, арга хэмжээ зохион байгуулах зорилгоор төв болон Агаарын замын боомт хариуцсан газар, Дорноговь аймаг дахь газрын 104 албан хаагчаас сорил авлаа.







